

3-ГТ-1

ГАЛ ТҮЙМРИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Маягт 3-ГТ-1-ийг гал түймрийн тохиолдлын талаарх мэдээллийг бүртгэхэд ашиглана.

Тухайн гал түймрийг дуудлагаар очсон гал түймэр унтраах, аврах анги, салбар өөрийн хүчээр бүрэн унтрааж аюулт үзэгдлийг зогсоосон бол энэхүү маягыг бүрэн гүйцэд бөглөж мэдээллийн санд бүртгэнэ.

Хэрэв тухайн гал түймэр дуудлагаар болон нэмэлтээр очсон гал түймэр унтраах, аврах анги, салбарын хүчин чадлаас давж орон нутгийн төрийн захиргааны байгууллага, Засаг дарга эсхүл тухайн шатны онцгой комисс, холбогдох салбарын яамнаас шуурхай бүлэг, ажлын хэсэг томилсон бол III, IV бүлгийг томилогдсон бүлэг, ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ.

Ойлголт, тодорхойлолт:

"Гал түймэр" гэж гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг хэлнэ.

(*"Галын аюулгүй байдлын тухай хууль"-ийн 3.1.1-д зааснаар*)

БҮЛЭГ I ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**1. Гал түймрийн голомтын бүс**

"Голомтын бүс" гэж гамшиг, аюулт үзэгдэл болон ослын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг хэлнэ.

(*"Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 4.1.11-т зааснаар*)

1.1. Аймаг, нийслэл: Тухайн гал түймрийн тохиолдол гарсан аймаг, нийслэлийн нэрийг гаргацтай бичиж, кодыг нөхнө.

"аймаг, нийслэлийн код"-ийг Монгол Улсын бүсчлэлийн кодын дагуу нөхнө.

Тухайлбал; Архангай аймаг 65000, Хөвсгөл аймаг 67000

Хамарсан тоо Тухайн гал түймэр хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ.

1.2. Сум, дүүрэг: Тухайн гал түймрийн тохиолдол гарсан сум, дүүргийн нэрийг гаргацтай бичиж, холбогдох кодыг нөхнө.

"сум, дүүргийн код"-ийг Монгол Улсын бүсчлэлийн кодын дагуу нөхнө. Тухайлбал, Архангай аймгийн Хашаат сум 65010, Хөвсгөл аймгийн Мөрөн сум 67120

Хамарсан тоо Тухайн гал түймэр хэдэн сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ

1.3. Баг, хороо: Тухайн гал түймрийн тохиолдол гарсан баг, хорооны нэрийг гаргацтай бичнэ.

Хамарсан тоо Тухайн гал түймэр хэдэн баг, хорооны нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ

1.4. Хаяг: Тухайн гал түймрийн тохиолдол гарсан газрын хаягийг гаргацтай, тодорхой бичнэ.

1.5. Солбицол: Уртраг, өргөргийг оруулахдаа градус, минут, секундээр илэрхийлэн бичнэ.

1.6. Гурван үгт хаяг: Ухаалаг гар утасны what3words программыг ашиглан авсан байршлын 3 үгийг бичнэ. Жишээлбэл: жаалхүү.уриалах.аврагч гэх мэт. Координат нь тодорхой бол бичихгүй байж болно.

1.7. Мэдээлэл хүлээж авсан огноог он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ. Цагийг 01.00-24.00 хэлбэрээр бичнэ.

1.8. Эх сурвалж: гал түймрийн мэдээллийг ирүүлсэн эх сурвалжийг сонгоно.

1.9. Мэдээлэл өгсөн хүн: гал түймрийн дуудлага мэдээллийг ирүүлсэн хүний утасны дугаар, нэрийг бичиж хүйсийг тэмдэглэнэ.

1.10. Мэдээлэл хүлээн авсан сувгийг тэмдэглэнэ.

1.11. Мэдээллийн товч утга: Хүлээн авсан мэдээллийн товч утгыг бичнэ.

1.12. Гал түймрийн төрөл

Гал түймрийн төрлийг ойн, хээрийн, объектын гал түймэр гэсэн төрлөөр ялган бүртгэж харгалзах 1, 2, 3 гэсэн дугаарыг дугуйлна.

Ой, хээрийн гал түймэр гэж ой болон хээрийн бүсэд шатамхай ургамлаар дамжин гал хяналтгүй тархахыг хэлнэ.

Ойн хөрсний гадаргуу дээрх өвслөг ургамал, хүлэр ба ялзмагт давхраа, хагд өвс, хөвд, хаг, мод, сөөг, ой моддын иш, титэм галд их хэмжээгээр шатаж, тархахыг ойн гал түймэр гэж үзнэ.

Ой модгүй газрын өвс, ургамал, хаг галд их хэмжээгээр шатаж, тархахыг хээрийн гал түймэр гэж үзнэ.

Бүх төрлийн өмчийн хэлбэрийн барилга байгууламж, эд хөрөнгө, тоног төхөөрөмжид гарсан гал түймрийг объектын гал түймэр гэж үзнэ.

Тухайн гал түймрийн нөхцөл байдлаас шалтгаалан хэд хэдэн төрлийг давхар дугуйлж болно.

БАТАЛГААЖУУЛАЛТ - Гал түймэр гарсан тухай дуудлагыг хүлээн авч бүртгэсэн шуурхай удирдлагын оператор харьяа анги, салбар, цол, нэрийг гаргацтай бичиж гарын үсгээр баталгаажуулан тус тохиолдол дээр ажиллах салаа, бүлгийн дарга, захирагчид хүлээлгэн өгнө.

БҮЛЭГ II НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2. Хугацаа

Гал түймэр гарсан, дуудлага хүлээж авсан, дуудлагаар гарсан, хүрэлцэн очсон, тархалтыг зогсоосон, бүрэн унтраасан он, сар, өдөр, цаг, минутыг дарааллын дагуу бүрэн гүйцэд, гаргацтай

нөхөж бичнэ. Цагийг 01.00-24.00 хэлбэрээр бичнэ.

Үргэлжилж байгаа: Тухайн аюулт үзэгдэл, осол 48 цагаас дээш хугацаагаар үргэлжилж байгаа бол харгалзах хугацааг сонгоно.

3. Гал түймрийн нөхцөл байдал

Гал түймрийн тухайн цагийн байдалд үнэлгээ өгч, гал түймэр унтраах, аврах анги, салбар, бүлгийн гал түймэр унтраах үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэр гаргах, шалтгаан нөхцлийг тогтоох зорилгоор гал түймрийн үед орчны болон галын нөхцөл, бодит байдлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг бүртгэнэ.

1 дүгээр мөрөнд гал түймрийн тархах хурдыг тодорхойлон бүртгэнэ. Галын түймрийн тархах хурд нь нэгж хугацаанд галын тархалт, байршилд гарсан өөрчлөлтийг харуулна. Галын тархах хурдыг м/с -ээр хэмжин нөхнө.

2 дугаар мөрөнд гал түймрийн тохиолдол гарсан байршлын агаарын дундаж температур, даралтыг нөхнө. Агаарын температур, даралтыг цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан тухайн өдрийн албан ёсны мэдээгээр нөхнө.

3 дугаар мөрөнд гал түймрийн тохиолдол гарсан байршлын салхины хурдыг нөхнө. Салхины хурдыг м/с-ээр хэмжинэ. Салхины хурдыг цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан тухайн өдрийн албан ёсны мэдээгээр нөхнө.

4 дүгээр мөрөнд гал түймрийн тохиолдол гарсан байршлын салхины чиглэлийг нөхнө. Салхины чиглэлийг цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан тухайн өдрийн албан ёсны мэдээгээр нөхнө.

5 дугаар мөрөнд гал түймрийн тохиолдол гарсан байршлын салхины чиглэлийн өөрчлөлтийн тоог нөхнө. Салхины чиглэлд гарсан өөрчлөлтийг тухайн үед гарсан өөрчлөлтийн давтамжийн тоогоор бүртгэнэ.

6 дугаар мөрөнд гал түймрийн тохиолдол гарсан байршлын тухайн үеийн чийгшлийн хэмжээг нөхнө. Чийгшлийн хэмжээг хувиар хэмжих бөгөөд цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан тухайн өдрийн албан ёсны мэдээгээр нөхнө.

7 дугаар мөрөнд тухайн гал гарсан байршлаас усан хангамж хүртэлх зайг нөхнө. Хэмжих нэгж нь км байна.

8 дугаар мөрөнд гал түймэр гарсан объектын галд тэсвэржилтийн зэргийг 1-5 хүртэлх байдлаар нөхнө.

9 дүгээр мөрөнд гал түймэр гарсан объектын дотор тэсэрч дэлбэрэх бодис байсан эсэхийг тэмдэглэнэ.

10 дугаар мөрөнд гал түймэр гарсан объектын автомат дохиоллын болон унтраах систем ажилласан эсэхийг тэмдэглэнэ.

4. Гал түймрийн нөхцөл байдлын зургийг гамшгийн орон зайн мэдээллийн системд зураглах бөгөөд нөхцөл байдлын зургийг хавсаргаагүй бол тайлбарыг бичнэ. Нөхцөл байдлын зурагт хүснэгт 2, 7, 10-д заасан мэдээллийг тэмдэглэнэ. Нөхцөл байдлын зураг нь 21x29 /A4/ хэмжээнээс багагүй байна.

5. Гал түймрийн шалтгаан

Гал түймэр гарсан шалтгааныг тухайн үеийн эхний үзлэгээр “урьдчилсан” багананд сонгож, улсын байцаагчийн дүгнэлт гарсны дараа “батлагдсан” багананд сонгоно.

1 дүгээр мөрөнд ил задгай асгасан үнс, нурам, тамхи, чүдэнзний галыг унтраалгүйгээр ил задгай хаях, автомашин, тээврийн хэрэгслийн оч баригчгүй яндангаас гарсан гал түймэр зэргээс шалтгаалсан гал түймрийг хамруулна.

2 дугаар мөрөнд цахилгаан дамжуулах утасны хэт ачаалал, богино холболт, шилжилтийн эсэргүүцлээс үүсвэрлэн гарсан гал түймрийг авч үзнэ.

3 дугаар мөрөнд пийшин зуухны ашиглалт, яндангийн хэт халалт, цонолтоос үүсвэрлэн гарсан гал түймрийг авч үзнэ.

4 дүгээр мөрөнд үйлдвэрлэл, ашиглалтын явцад технологийн горим зөрчигдсөнөөс үүсвэрлэн гарсан гал түймрийг авч үзнэ.

5 дугаар мөрөнд байгаль, цаг уурын үзэгдлээр буюу аянга цахилгаан, үрэлт, хэт халалт зэргээс шалтгаалж гарсан гал түймрийг авч үзнэ.

6 дугаар мөрөнд цагдаагийн байгууллага, шүүхээр гэм буруутай нь тогтоогдож, дээрх шалтгаан нөхцлүүдээр гал түймэр тавьсныг авч үзнэ.

7 дугаар мөрөнд ахуйн хий ашиглалт /газ/-ын буруутайгаас үүдэлтэй гарсан гал түймрийг авч үзнэ.

8 дугаар мөрөнд шатах болон тослох материалаас үүдэлтэй гарсан гал түймрийг авч үзнэ.

9 дүгээр мөрөнд 1-8 дугаар мөрөнд тавигдсан шалтгаанаас бусад гал түймрийн шалтгааныг хамруулан үзнэ.

6. Гал түймрийг унтраахад ашигласан арга

Тухайн гал түймрийг унтраахад ашигласан аргыг сонгож дугуйлна. Хэд хэдэн аргыг хамтад нь сонгож болно.

7. Гал түймрийг унтраасан нотломжийг хавсаргана.

8. Ажилласан хүч, хэрэгсэл

Ажилласан хүч, хэрэгсэлд тухайн гал түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэн ажилласан гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, нутгийн захиргааны байгууллага, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, дайчлагдан ажилласан болон олон улсын байгууллага, бусад байгууллага, хувь хүнийг хамруулна.

Гал түймрийг унтраахаар ажилласан анги, салбар, бүлэг, хэсэг, хүн, ашигласан техникийн тоог нөхнө.

БҮЛЭГ III ХОХИРОЛ, ХЭРЭГЦЭЭ

9. Гал түймрийн унтраахад зарцуулсан зардал

Гал түймрийг унтраахад зарцуулсан зардлыг онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, нутгийн захиргааны байгууллага, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, дайчлагдан ажилласан болон олон улсын байгууллага, бусад эх үүсвэрээс гаргасан зардлаар ангилан зардлын задаргааг байгууллага тус бүрээр албажуулан хавсаргана. Хэмжих нэгж нь сая төгрөг байна.

2 дугаар мөрөнд гал түймрийг унтраахад зарцуулсан шатахууны зардлын дүнг бичнэ.

3 дугаар мөрөнд гал түймрийг унтраах ажиллагаанд зарцуулсан хоол, хүнсний зардлын дүнг бичнэ.

4 дүгээр мөрөнд гал түймэр унтраах ажиллагаанд зарцуулсан шуудан холбооны зардлын дүнг бичнэ.

5 дугаар мөрөнд гал түймэр унтраахад ажилласан алба хаагчдын томиллолт, урамшууллын зардлын дүнг бичнэ.

6 дугаар мөрөнд гал түймэр унтраах ажиллагаанд зарцуулсан ариутгал, халдваргүйтгэлийн зардлын дүнг бичнэ.

7 дугаар мөрөнд гал түймэр унтраах ажиллагаанд зарцуулсан эм, боох материалын зардлын дүнг бичнэ.

8 дугаар мөрөнд гал түймэр унтраах ажиллагаанд улсын нөөцөөс зарцуулсан хөрөнгийг нөхөн бүрдүүлэх зардлын дүнг бичнэ.

9 дүгээр мөрөнд дээрх 1-8 дугаар мөрөнд тавигдсан зардлаас бусад зардлыг бичнэ.

10. Гал түймэрт нэрвэгдсэн хүн амын үндсэн үзүүлэлт

Гал түймэрт нэрвэгдсэн хүн амыг нийт дүн, хүйс, өгөгдсөн насны бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй, гадаадын иргэн гэсэн үзүүлэлтүүдээр ялгана.

“гадаадын иргэн” гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг хэлнэ.

Нас барсан хүний дэлгэрэнгүй бүртгэлийг маягтын дагуу хавсаргана.

1 дүгээр мөрөнд гал түймэрт нэрвэгдсэн хүний тоог нөхнө. Тухайн гал түймрийн улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон иргэдийг авч үзнэ.

2 дугаар мөрөнд гал түймэрт өртөж нас барсан иргэдийн тоог бичнэ.

3 дугаар мөрөнд гал түймрийн голомтоос онцгой байдлын байгууллагын алба хаагч буюу бусад иргэдийн аварсан хүний тоог бичнэ.

4 дүгээр мөрөнд гал түймрийн улмаас түлэгдэж, гэмтсэн иргэдийн тоог бичнэ.

5 дугаар мөрөнд гал түймрийн голомтын бүсээс онцгой байдлын байгууллагын алба хаагчдын тусламжтайгаар гарсан иргэдийн тоог бичнэ.

6 дугаар мөрөнд гал түймэрт өртөж орон байр, гэргүй болсон иргэдийн тоог бичнэ.

7 дугаар мөрөнд гал түймрийн улмаас орон байр, гэр сууцанд хохирол учирсан иргэдийн тоог бичнэ.

8 дугаар мөрөнд гал түймрийн улмаас сураггүй алга болсон иргэдийн тоог бичнэ.

9 дүгээр мөрөнд гал түймрийн улмаас орон байр, гэр сууцанд хохирол учирснаас аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлсэн иргэдийн тоог бичнэ.

11. Гал түймэрт нэрвэгдсэн өрх, байгууллагын үндсэн үзүүлэлт

Гал түймэрт нэрвэгдсэн өрх, байгууллагын тоог албан ёсны бүртгэл, тухайн үед байсан, орон байр, гэргүй болсон, орон байр, гэр нь эвдэрсэн зэрэг үзүүлэлтээр ялган нөхнө.

12. Учирсан бодит хохирол

Тухайн гал түймэрт өртсөн талбайг “га”-аар, бусад барилга байгууламж, гэр, байр орон сууцыг тоогоор нөхнө.

Учирсан хохирлын мөнгөн дүнг гамшгийн хор уршгийг арилгах үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээ, хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээгээр нарийвчлан тогтооно.

1 дүгээр мөрөнд гал түймэрт өртсөн ой, хээрийн талбайн нийт хэмжээг нөхнө.

2 дугаар мөрөнд тухайн гал түймэрт өртсөн ойн талбайг өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

3 дугаар мөрөнд тухайн гал түймэрт өртсөн тариалангийн болон бэлчээрийн талбайн нийт хэмжээг нөхнө.

4 дүгээр мөрөнд тухайн гал түймэрт өртсөн тариалангийн талбайн хэмжээг өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

5 дугаар мөрөнд тухайн гал түймэрт өртсөн бэлчээрийн талбайн хэмжээг өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

6 дугаар мөрөнд гал түймэрт өртсөн гэр, байр, орон сууцны нийт тоог нөхнө.

7 дугаар мөрөнд гал түймэрт өртсөн гэрийн нийт тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

8 дугаар мөрөнд гал түймэрт өртсөн байр, орон сууцны нийт тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

9 дүгээр мөрөнд гал түймэрт өртөж шатсан малын болон айлын хашаа, саравчны нийт тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

10 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан тэжээлийн болон боодлын өвсийг өмчийн хэлбэрийн хамт нөхнө. /Задгай өвсийг боодлын өвсөнд шилжүүлнэ/

11 дүгээр мөрөнд гал түймэрт өртөж шатсан тээврийн хэрэгслийн тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө. Үүнд агаарын хөлөг, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, автомашин, усан онгоц, завь, ердийн хөсөг зэргийг хамааруулна.

12 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан нийт барилга, байгууламжийн тоог нөхнө.

13 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан улсын онц чухал объектын тоог нөхнө.

“улсын онц чухал объект” гэж Монгол Улсын Засгийн газраас тогтоосон улс орны нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий үйлдвэр, албан газар, байгууллага, барилга байгууламжийг хэлнэ.

14 дүгээр мөрөнд галын онц аюултай объектын тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

15 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан эмнэлэг, эрүүл мэндийн барилга, байгууламжийн тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө. Үүнд эрүүл мэндийн төв, эмнэлэг, хувийн эмнэлэг зэргийг хамааруулна.

16 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан боловсролын байгууллагын барилга, байгууламжийн тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө. Үүнд их, дээд сургууль, коллеж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, зуслан, мэргэжил-сургалт үйлдвэрлэлийн төв, сургалтын төв, хүүхдийн засан хүмүүжүүлэх төв зэргийг хамааруулна.

17 дугаар мөрөнд гал түймэрт өртсөн дэд бүтцийн байгууламжийн нийт тоог нөхнө.

18 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан эрчим хүчний дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд шугам сүлжээ, дамжуулах шугам/сүлжээ, цахилгаан станц, дэд станц болон дахин дамжуулах станцыг хамааруулна.

19 дүгээр мөрөнд гал түймэрт өртөж шатсан зам тээврийн дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд хучилттай зам, сайжруулсан зам, гүүр, төмөр зам, төмөр замын өртөө, нисэх буудал зэргийг хамааруулна.

20 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд холбооны шугам, харилцаа холбооны тоног төхөөрөмж зэргийг хамааруулна.

21 дүгээр мөрөнд гал түймэрт өртөж шатсан усан хангамжийн дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд ус түгээх сүлжээ, ус цэвэрлэх байгууламж, худаг зэргийг хамааруулна.

22 дугаар мөрөнд Засгийн газрын барилга, байгууламжийн тоог нөхнө.

23 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан хамгаалах дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд үерээс хамгаалах далан, ус зайлуулах систем, түр хоргодох байр, аюулыг хянах, зарлан мэдээлэх дэд бүтэц, нөөцийн агуулах зэргийг хамааруулна.

24 дүгээр мөрөнд гал түймэрт өртөж шатсан ногоон дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн зүлэгжүүлсэн талбай, усан сан, оргилуур, хотын ногоон байгууламж зэргийг хамааруулна.

25 дугаар мөрөнд гал түймэрт өртөж шатсан хогийг тоон байдлаар нөхнө.

26 дугаар мөрөнд гал түймэрт өртөж хорогдсон малын нийт тоог нөхнө.

27 дугаар мөрөнд гал түймэрт өртөж хорогдсон бод малын тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

28 дугаар мөрөнд гал түймэрт өртөж хорогдсон бог малын тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

29 дугаар мөрөнд гал түймэрт өртөж хорогдсон тэжээвэр амьтны тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

30 дугаар мөрөнд гал түймэрт өртөж хорогдсон ан амьтны тоог нөхнө.

Тухайн гал түймэр цаашид тархан дэлгэрэх аюултай ТИЙМ гэснийг сонгосон тохиолдолд Хэрэгцээний тойм хүснэгтийг бөглөнө.

13. Аварсан эд хөрөнгө

Гал түймрийн аюулаас авран хамгаалсан эд хөрөнгийг үзүүлэлтийн дагуу тоо ширхэг, өмчийн хэлбэр, аварсан хөрөнгийн дүнгийн хамт нөхнө.

14.Хэрэгцээний тойм

Хэрэгцээний тойм хүснэгтэд гамшигт нэрвэгдсэн хүн амын анхдагч хэрэгцээг хангахад шаардлагатай тусламж, үйлчилгээний мэдээлэл, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд шаардагдах хүч хэрэгсэл, зардлын тооцоо, хойшлуулшгүй сэргээн босгох

үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, санхүү, техникийн мэдээллийг тоон байдлаар бөглөнө.

БҮЛЭГ IV ГАМШГИЙН ТҮВШИН, ЗЭРЭГЛЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг ашиглан гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны онцгой комисс гамшгийн зэрэглэлийг тогтооно.

/ЗГ-ын 2018 оны 327 дугаар тогтоол “Гамшгийн зэрэглэл тогтоох журам”-ын 3.2-т зааснаар/

15. Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

Тухайн гал түймрийн үзүүлэлтийг үр дүнгээр багананд нөхөж шалгуурыг давсан эсэхийг үнэлнэ.

16. Гамшгийг тодорхойлох

Тухайн гамшгийн төрөлд хамаарах нийт шалгуур үзүүлэлтийн 50 хувь нь бүрдсэн байвал гамшиг болсонд тооцно.